



**ТАВАН БОГД КАПИТАЛ**  
**БОЛОМЖОО БОЛИТ БОЛГО**

# БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2022 ОНЫ 6 ДУГААР САР

2022.07.29

# Банкуудын зээл олголт, багц

**Нийт актив**  
**₮42.1 их наяд**  
**Нийт зээл**  
**₮23.2 их наяд**  
**Хадгаламж**  
**₮17.5 их наяд**  
**Харилцах**  
**₮8.2 их наяд**  
**Өөрийн**  
**хөрөнгө**  
**₮4.7 их наяд**

## Банкны салбарын ерөнхий тойм


Монгол улсад нийт 12 арилжааны банк байдаг. Улаанбаатар хот болон орон нутагт нийт 1,391 салбар нэгж, 15,921 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод нийт 409 салбар нэгж, гадаадад 4 салбар байршиж байна. Арилжааны банкуудаас Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк болон Хас банк нь системийн нөлөө бүхий банк юм.

## Банкуудын зээл олголт, зээлийн багц


» Тайлант сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.6% өсөж, 23.2 их наяд төгрөг болсон байна. Тодруулбал өмнөх оны мөн үеэс хувийн байгууллагын зээл 19.5 хувиар өсч 10.9 их наяд төгрөгт, иргэдийн зээл 28.8 хувиар өсч 12 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн 1.4 их наяд төгрөг буюу 6.0% нь гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, үлдсэн 94.0% нь төгрөгөөр олгогдсон зээл байна. Мөн зээлийн нийт үлдэгдлийн 46.9% нь хувийн байгууллага, 0.8% нь улсын байгууллага, 52.1% нь иргэдийн зээл, үлдсэн 0.2% нь бусад байгууллагуудад олгогдсон зээл байна.

» Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 503.9 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 232.6 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Доорх зурагт 6 дүгээр сард олгогдсон болон төлөгдсөн зээлийг өмнөх тайлант сартай харьцуулсан дэлгэрэнгүйг харуулав. 6-р сарын хувьд зээл олголт болон эргэн төлөлт багассан байгаа нь бодлогын хүү өсөж, зээлийн өртөг ихссэнтэй холбоотой байх магадлалтай юм.

Зураг 1: 2022 оны 5-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)



Зураг 2: 2022 оны 6-р сард олгосон, төлөгдсөн зээл (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Монголбанк

# Банкуудын зээл олголт, багц

2022 оны 6 дугаар сарын байдлаар нийт зээлийн багц 23.2 их наяд төгрөг байна. Өмнөх сартай харьцуулахад 204.7 тэрбум төгрөгөөр өссөн байгаа ба үүнээс хувийн байгууллагын зээлийн багцын үлдэгдэл 9.3 тэрбум төгрөгөөр өсөж 10.8 их наяд, иргэдийн зээл 221.7 тэрбум төгрөгөөр өсөж 12 их наяд болжээ.

Харин зээлийн багцын хувьд 21.1%-ийг бөөний болон жижиглэн худалдаа, 15%-ийг үл хөдлөх хөрөнгө, 8.2%-ийг барилга, 7.6%-ийг боловсруулах үйлдвэрлэл, 7.1%-ийг уул уурхай, салбарт олгосон байна. Энэ тус салбарууд зээлийн санхүүжилтийн хэлбэрийг илүүл үзэж үйл ажиллагаа явуулж байгааг харж болох ба өмнөх сарын зээл олголттой харьцуулахад төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

Тайлант сард нийт хэвийн зээлийн дүн 19.9 их наяд төгрөг, үүний 57% нь 1-5 жилийн хугацаатай, 24% нь урт хугацаат зээлүүд байна. Харин чанаргүй зээл өмнөх сараас 16.6 тэрбум төгрөгөөр буурч, 2.1 их наяд төгрөг болсон байна.

Чанаргүй зээлийг бүтцээр нь задалбал:

26.6% - уул уурхай

18.4% - боловсруулах салбар

13.8% - барилга

7.3% - үл хөдлөх

6.1% - худалдаа


3.7% - хөдөө аж ахуйн зээл байна.

Мөн нийт чанаргүй зээлийн 9.5% нь гадаад валютын зээл байна.


Зураг 4: Зээлийн бүтэц, салбараар



Зураг 5: Зээлийн чанарын ангилал



Зураг 6: Чанаргүй зээлийн бүтэц, салбараар



Эх сурвалж: Монголбанк

# ЗЭЭЛИЙН ЖИГНЭСЭН ДУНДАЖ ХҮҮ

## Зээлийн жигнэсэн дундаж хүү

2022 оны 6-р сарын нийт зээлийн үлдэгдлээр тооцсон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар буурч 15.4%, валютын хүү 0.7 нэгж хувиар өсч 9.9% болсон байна. Энэ нь валютын ханшийн өсөлтийн нөлөөлөл бөгөөд төгрөг ам. долларын эсрэг сулрахын хэрээр төгрөгийн дундаж хүү буурч, валютын хүү өсөж байгаа билээ.


Харин шинээр олгосон төгрөгийн зээлийн хүү өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.2 нэгж хувиар буурч 14.6% байгаа бол валютын зээлийн хүү өмнөх оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсч 8.8% байна.

Тайлант хугацаанд шинээр олгосон зээл, шинээр татсан нийт хадгаламжийн хүүгийн зөрүү 7.1% гарсан ба өмнөх оны мөн үед уг зөрүү 8.7% байсан юм. Харин шинээр татсан хугацаатай хадгаламжийн дундаж хүүтэй харьцуулбал зөрүү 7.4% юм.


Тус сар иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 15.0% байхад хувийн байгууллагуудад олгосон зээлийн хүү 14.3% байна.

Харин иргэдийн төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 15.8 хувь, гадаад валютынх 14.1 хувь байна. Хувийн байгууллагын төгрөгийн зээлийн үлдэгдлийн ЖДХ 14.7 хувь, гадаад валютынх 9.8 хувь байна. Үлдэгдэлд болон олгосон зээлд тооцсон хүүгийн хувьд иргэдийн зээлийн хүү байгууллагын зээлийн хүүнээс илүү байгаа юм.


Зураг 6: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү



Зураг 7: Шинээр олгосон зээл, хадгаламжийн хүүгийн зөрүү



Зураг 8: Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү, салбараар



Эх сурвалж: Монголбанк

**Нийт актив**  
**₮42.1 их наяд**  
**Нийт зээл**  
**₮23.2 их наяд**  
**Хадгаламж**  
**₮17.5 их наяд**  
**Харилцах**  
**₮8.2 их наяд**  
**Өөрийн**  
**хөрөнгө**  
**₮4.7 их наяд**

## Банкуудын харилцах, хадгаламж

2022 оны 6-р сарын байдлаар нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 6.7%-аар буурч, харилцахын үлдэгдэл 11.9%-аар өссөн байна. Үүнээс, төгрөгийн хадгаламж 29.8%-аар буурч, гадаад валютаар илэрхийлэгдэх хадгаламжийн хэмжээ 13.4%-аар буурсан байна. Энэ нь иргэд, аж ахуйн нэгжүүд мөнгөө хадгалах сонирхол буурч байгааг илтгэж байна. Мөн валютын харилцах хамгийн өндөр хувиар буюу 54.0% өсөлт үзүүлжээ.

Тайлант сард шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 7.5%, гадаад валютын хадгаламжийн ЖДХ 1.8% байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх сараас 0.1 нэгж хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан бол валютын хадгаламжийн ЖДХ өмнөх сараас өөрчлөгдөөгүй ба өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан байдалтай байна. Зураг 9-д шинээр татсан хугацаатай хадгаламжийн хүүг харуулав.


## Ипотекийн зээл олголт

2022 оны 6-р сард нийт 1,108 иргэнд нийт 108.1 тэрбум төгрөгийн зээлийг шинээр олгосон бөгөөд сарын эцсийн байдлаар нийт 105,679 зээлдэгчийн 5.99 их наяд төгрөгийн ипотекийн зээл байна. Сарын турш нийт 108.1 тэрбум төгрөгийн шинэ зээл олгогдож, 25.4 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгджээ.

Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 6.9% хувьд хүрч, өмнөх сараас 0.44 нэгжээр буурав.

Тайланд сард нийт 36.1 тэрбум төгрөг хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн ангилалд байна. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалтай зээлийн задаргааг Зураг 11-т дэлгэрэнгүй харуулав.

Зураг 9: \*Хадгаламжийн хүү



\*Тайлбар: Шинээр татсан нийт хадгаламж болон хугацаатай хадгаламжийн хүү хоорондоо ялгаатайг анхаарна уу.

Зураг 11: Хугацаа хэтэрсэн болон чанаргүйд ангилагдсан ипотекийн зээлийн багц /тэрбум.төг/



Эх сурвалж: Монголбанк



# Макро эдийн засгийн орчин

## Макро эдийн засгийн орчин

### Гадаад худалдааны тэнцэл:

2022 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,884 сая ам.доллаар өсөж 9,256 сая ам.долларт хүрсэн байна. Үүнд экспорт 29%-аар буюу 1,197 сая ам.доллаар, импорт 21%-аар буюу 687 сая ам.доллаар өссөн нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 510 сая ам.доллаар өсөж 1,360 сая ам.долларын ашигтай гарлаа.

### Экспорт: 5.3 тэрбум ам.доллар (29%↑)

2022 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн 29%-аар буюу 1,197 сая ам.доллаар өсөж 5,308 сая ам.долларт хүрчээ. Экспорт нийт 29 хувиар өсөхөд 33 нэгж хувийг уул уурхайн бүтээгдэхүүний өсөлт бүрдүүлсэн байна.

### Импорт: 3.9 тэрбум ам.доллар (21%↑)

2022 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21%-аар буюу 687 сая ам.доллаар өсөж 3,948 сая ам.долларт хүрчээ. Импорт 21 хувиар өсөхөд хэрэглээний бүтээгдэхүүний импорт 9 нэгж хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 9 нэгж хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

### Инфляц, бодлогын хүү:


Улсын инфляц 2022 оны 6 дугаар сарын байдлаар 1.5 хувь, жилийн инфляц 15.1 хувь байна. Улаанбаатар хотын хэмжээнд 16.9% гарав. Барааны бүлгээр авч үзвэл 10.9 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 5.3 нэгж хувийг хүнсний бараа бүрдүүлж байна. Хүнсний бүлгийн үнийн өсөлтөд талх, гурил, будаа болон ногооны үнэ, хүнснээс бусад барааны үнийн өсөлтөд шатахууны үнэ голлон нөлөөлжээ.

### Гадаад валютын ханш, албан нөөц:


Төгрөгийн ам.доллартой харьцах ханш сарын эцсийн байдлаар 3,134.1 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.4 хувиар, өмнөх оны мөн үеэс 10.01 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 3,124.25 төгрөг байв.

Харин төгрөгийн юаньтай харьцах сарын эцсийн ханш өмнөх сараас 0.1 хувиар, өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар суларч 468.09 төгрөгт хүрэв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 457.49 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 468.63 төгрөг байлаа.

Зураг 12: Төгрөг ам.долларын эсрэг (сарын хөдөлгөөнөөр)



Зураг 13: Төгрөг юанийн эсрэг (сарын хөдөлгөөнөөр)



Эх сурвалж: Монголбанк

# АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

Банк Реформер, IPO, Бонд, Хувьцаа



**ТАВАН БОГД КАПИТАЛ**  
БОЛОМЖОО БОЛИТ БОЛГО



**С.ТҮВШИНЗАЯА**

Андеррайтерийн хэлтсийн дарга

☎ 9912-2583

✉ [tuvshinzaya@tavanbogdcapital.com](mailto:tuvshinzaya@tavanbogdcapital.com)



**Б.МЯГМАРСҮРЭН**

Шинжээч

☎ 9527-9442

✉ [myagmarsuren.b@tavanbogdcapital.com](mailto:myagmarsuren.b@tavanbogdcapital.com)



**Б.АНАНД**

Шинжээч

☎ 9973-7090

✉ [anand.b@tavanbogdcapital.com](mailto:anand.b@tavanbogdcapital.com)



**Б.ГАН-ЭРДЭНЭ**

Хуулийн зөвлөх

☎ 8004-5151

✉ [ganerdene.b@tavanbogdcapital.com](mailto:ganerdene.b@tavanbogdcapital.com)

☎ 9502-9966, 9502-4664, 9400-4442

✉ [cr@tavanbogdcapital.com](mailto:cr@tavanbogdcapital.com)

🌐 [www.tavanbogdcapital.com](http://www.tavanbogdcapital.com)